



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань Увс” ХХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2023/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М. Батсуурь Утас: 70453317 Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М. Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн аудитор: В. Сэлэнгэ Утас: 9902-3656 Цахим хаяг: ariuntuqsorshihuaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	12
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт	13
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
“ЧАНДМАНЬ-УВС” ХХК-ийн
ЗАХИРАЛ Б.ЦЭЦЭЭ ТАНАА

2022 03.15 № УВА-2023/07/НА-СТА-ОНА
танай -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань Увс” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань Увс” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2022 онд 41,400.9 мянган төгрөгийн 9.8 тн шатах тослох материал зарцуулахдаа замын хуудас хөтлөхгүй, хяналтгүйгээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтууд, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

0200000210

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань Увс” ХХК –ийн Хөдөлмөрийн дотоод журамд үндэслэн захирлын тушаалаар тэтгэмж, тэтгэлэг, шагнал урамшуулал олгох асуудлыг бусад хууль тогтоомжид нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэв.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	183,684,906.00	156,328,775.60
1.1.02	Дансны авлага	219,356,680.10	61,739,981.54
1.1.04	Бусад авлага	0.04	0.60
1.1.06	Бараа материал	185,822,976.90	205,136,290.60
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	99,941,761.00	600,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	688,806,324.00	423,805,048.30
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	6,949,524,415.00	7,082,347,411.00
1.2.02	Биет бус хөрөнгө	1,618,699,425.00	1,617,029,294.00
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	200,000.00	200,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,568,423,840.00	8,699,576,706.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,257,230,164.00	9,123,381,754.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	60,439,375.89	35,792,162.80
2.1.1.02	Цалингийн өглөг	0.06	-
2.1.1.03	Татварын өр	75,213,639.55	16,541,635.08
2.1.1.06	Хүүний өглөг	756,279.70	429,818.07
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	258,062.18	258,062.18
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	136,667,357.40	53,021,678.13
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	945,568,200.00	851,068,200.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	945,568,200.00	851,068,200.00

2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,082,235,557.00	904,089,878.10
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	7,033,224,514.00	7,413,082,058.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	500,496,180.40	500,496,180.40
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,619,316,571.00	1,619,316,571.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(978,042,658.70)	(1,313,602,934.00)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(335,560,274.90)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(978,042,658.70)	(978,042,658.70)
2.3.10		-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,174,994,607.00	8,219,291,876.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,257,230,164.00	9,123,381,754.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,439,682,814.00	1,419,169,675.00
2	Борлуулалтын өртөг	1,388,131,309.00	1,334,817,788.00
3	Нийт ашиг(алдагдал)	51,551,504.77	84,351,886.67
10	Ерөнхий ба удирдлагын зардал	219,481,837.80	230,698,317.90
12.1	Зардлын дүн	219,481,837.80	230,698,317.90
17	Бусад ашиг (алдагдал)	(77,966,309.10)	(189,213,843.70)
17.1	Олз, гарзын дүн	(77,966,309.10)	(189,213,843.70)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(245,896,642.10)	(335,560,274.90)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(245,896,642.10)	(335,560,274.90)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(245,896,642.10)	(335,560,274.90)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(245,896,642.10)	(335,560,274.90)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

	Үзүүлэлт	Тайлант хугацааны дүн	Өмнөх оны дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,852,003,889.00	1,806,866,259.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,665,131,418.00	1,600,273,008.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,043,110.00	6,028,179.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	185,829,361.00	200,565,072.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,705,907,984.00	1,809,075,422.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	600,180,376.10	538,514,364.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	173,804,008.50	170,155,090.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	85,591,150.00	10,044,232.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	189,685,239.00	151,536,179.20
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	229,483,064.80	467,713,478.90
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	242,990,178.00	158,491,527.20
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,358,575.00	3,131,687.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	182,815,392.40	309,488,863.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	146,095,905.50	2,209,163.36
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	78,952,035.84	109,948,420.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	78,952,035.84	109,948,420.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-

2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	78,952,035.84	109,948,420.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	94,500,000.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	94,500,000.00	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	94,500,000.00	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,356,130.39	112,157,583.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	183,684,906.00	295,842,489.40
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	156,328,775.60	183,684,906.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	ХөрДахҮнНэм	ЭздӨмчБусХэсэг	ХурАшиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	7,033,224,514.00	500,496,180.40	1,619,316,571.00	(978,042,658.70)	8,174,994,607.00
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	7,033,224,514.00	500,496,180.40	1,619,316,571.00	(978,042,658.70)	8,174,994,607.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(335,560,274.90)	(335,560,274.90)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	379,857,544.00	-	-	-	379,857,544.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-

8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	7,413,082,058.00	500,496,180.40	1,619,316,571.00	(1,313,602,934.00)	8,219,291,876.00

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	I. НИЙТ ОРЛОГЫН ДҮН	мян.төг	1,439,682.8	1,358,554.3	1,419,169.6
	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	мян.төг	1,685,579.4	1,576,507.0	1,754,729.8
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	мян.төг	622,716.4	659,079.5	674,803.6
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	мян.төг	88,710.3	88,975.7	92,454.2
3	Цахилгаан эрчим хүч	мян.төг	74,816.8	78,160.7	79,742.4
4	Дулаан	мян.төг	-	25,005.6	
5	Хөдөлмөр хамгаалал	мян.төг	13,300.1	19,383.9	18,168.4
6	Сэлбэг хэрэгсэл	мян.төг	20,530.5	13,960.0	12,308.7
7	Түлш нүүрс	мян.төг	12,347.2	15,300.0	13,449.9
8	Материал түүхий эд	мян.төг	204,298.2	75,780.0	100,688.6
9	Томилолтын зардал	мян.төг	2,107.0	28,000.0	7,584.7
10	Тээврийн хэрэгсэл татвар, агаарын бохирдлын татвар оношлогоо	мян.төг	753.5	955.3	645.8
11	Газрын татвар	мян.төг	10,643.7	10,643.7	19,074.6
12	Холбоо, бичиг хэрэг, хэвлэл захиалга	мян.төг	8,022.5	8,668.7	9,325.0
13	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг	393,843.6	396,228.0	399,941.1
14	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	10,278.5	10,300.0	10,521.1
15	Хөрөнгө, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал	мян.төг	3,131.7	3,300.0	2,835.4
16	Бууны татвар	мян.төг		60.0	109.8
17	Бензин шатахуун	мян.төг	58,871.3	28,984.3	41,400.9
18	Ажлын хөлс, тээврийн хөлс, үйлчилгээний хөлс	мян.төг		10,000.0	34,326.8
19	Ус шинжилгээний зардал	мян.төг	71.1	1,350.0	692.0

20	Зар сурталчилгааны зардал	мян.төг	4,197.0	3,600.0	4,950.0
21	Сургалтын зардал	мян.төг	5,070.0	11,000.0	1,050.0
22	ТУЗ-ын зардал	мян.төг	17,227.1	17,934.4	14,490.5
23	Аудитын хөлс	мян.төг	3,360.0	3,360.0	4,400.0
24	Ариутгал халдваргүйжүүлэлт	мян.төг	264.0	600.0	20.0
25	Зохицуулах үйлчилгээний хөлс	мян.төг	5,374.9	6,000.0	6,085.1
26	Гишүүн байгууллагын татварууд	мян.төг	400.0	600.0	1,500.0
27	Шагнал урамшуулал	мян.төг	3,192.8	8,300.0	8,139.6
28	Буцалтгүй тусламж дэмжлэг	мян.төг	5,277.0	7,540.0	6,140.0
29	Түлш нүүрсний хөнгөлөлт	мян.төг	13,506.7	13,900.0	12,850.0
30	Баяр ёслол, баруун бүсийн тэмцээн уралдаан	мян.төг	4,963.4	8,500.0	11,123.5
31	Өндөр настанд хүндэтгэл үзүүлэх зардал	мян.төг	3,944.0	6,000.0	9,461.8
32	Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмж	мян.төг	5,091.0	10,037.2	10,037.2
33	Бусад зардал/хандив, тусламж/	мян.төг	528.9	2,000.0	2,520.0
34	Компанийн 70 жилийн ой тэмдэглэх зардал	мян.төг	7,200.0		
35	Ажлаас гарсан тэтгэмж	мян.төг	32,145.1		
36	Хоол	мян.төг	1,737.5		4,409.5
37	Эрүүл мэндийн үзлэг, вакцин	мян.төг	400.0		
38	Баруун бүсийн НААҮ-ний ажилчдын ажил мэргэжлийн уулзалт	мян.төг		3,000.0	8,127.6
39	Цэвэрлэх байгууламжийн шав тавих	мян.төг			1,996.5
40	Интернет утас холбоо	мян.төг			1,062.1
41	Хогны зардал	мян.төг			950.3
42	Замын засвар	мян.төг	47,257.6		126,843.1
43	Зөвлөгөөн	мян.төг			500.0
44	Нийт ашиг/алдагдал	мян.төг	(245,896.6)	(217,952.7)	(335,560.2)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Чандмань-Увс”ХХК, түүний үйл ажиллагаа

Нийтийн аж ахуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК нь Улаангом сумын айл өрх, аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, экологийн тэнцвэрт нийцсэн бохирыг байгальд нийлүүлэх зорилготой.

Усан хангамж, ариутгах татуурга, нийтийн халуун усаар хангах чиг үүрэгтэй бөгөөд компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Иргэд, байгууллага аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан унд ахуйн болон технологийн хэрэгцээний цэвэр усаар байнга тасралтгүй хангах, чанарын хяналт тавих.
- Хот суурины бохир усыг стандарт шаардлагын дагуу цэвэрлэж зайлуулах.
- Орон сууцны барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ хийх.
- Нийтийн халуун усны үйлчилгээ үзүүлэх.
- Үндсэн үйл ажиллагаанаас гадна улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагааг явуулж орлого ашигаа нэмэгдүүлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн нэгж ХХК гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 “Чандмань-Увс”ХХК-ийн гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Чандмань-Увс” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн ерөнхий болоод тусгай бодлогод тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно. Иймээс НББОУС-8-д тусгасан бодлогын өөрчлөлтөд нийцэх үйл явдал үүсээгүй болно.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн “Чандмань-Увс” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Увс аймгийн “Чандмань-Увс” ХХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн байдлын тайлан дахь нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,848.4 мянган төгрөгөөр буюу 7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	183,684.9	156,328.7	-27,356.2
Авлага	219,356.6	61,739.9	-157,616.7
Бараа материал	185,822.9	205,136.2	19,313.3
Үндсэн хөрөнгө	6,949,524.4	7,082,347.4	132,823.0
Нийт хөрөнгө	9,257,230.1	9,123,381.7	-133,848.4
Өр төлбөр	1,082,235.5	904,089.8	-178,134.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,174,994.6	8,219,291.8	44,297.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,257,230.1	9,123,381.7	-133,848.4

“Чандмань-Увс” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайланд толилуулсан хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчид гарсан өөрчлөлтийн материаллаг хэмжээг нарийвчлан толилуулбал дараах байдалтай байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 156,328.7 мянган төгрөг болж 27,356.2 мянган төгрөг буюу 15 хувиар буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 61,739.9 мянган төгрөг болж 157,616.7 мянган төгрөг буюу 72 хувь буурсан байна. Уг бууралтад урьд онд үүссэн Засгийн газраас авах усны хөнгөлөлт, чөлөөлөлтийн 150,660.4 мянган төгрөг төвлөрсөн нь нөлөөлсөн байна. Авлага дансны үлдэгдлийн 74 хувийг дотоодын байгууллагаас авах авлага болон байцаагч нарт хамаарах төлбөрт үйлчилгээний авлага эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 205,136.2 мянган төгрөг болж 19,313.3 мянган төгрөг буюу 10 хувь өссөн байна. Тайлант хугацаанд 327,771.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж 308,457.9 мянган төгрөгийн зарцуулалтыг НББОУС-2-д тусгасан аргуудаас өөрийн байгууллагын бараа материалын бүртгэлийн бодлогод тусгасан ЭАЭЗ аргаар бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,082,347.4 мянган төгрөг болж 132,823.0 мянган төгрөг буюу 2 хувь өссөн байна. Тайлант хугацаанд НББОУС-16, НББОУС-38-ийн дагуу хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцсэн 531,094.2 мянган төгрөгийн өртөг бүхий эргэлтийн бус хөрөнгийн анхдагч хэмжилт хийсэн. Эдгээрийг нарийвчлан үзвэл өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан 41,288.3 мянга, худалдан авсан 109,948.4 мянга, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 379,857.5 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө нэмэгдсэн байна. Дараа үеийн хэмжилтийн хувьд барилга байгууламжийн ангилалд дахин үнэлгээний загвар, тавилга эд хогшил ба компьютер бусад хэрэгсэлийн ангилалд өртгийн загвараар тус тус толилуулсан байна. Тайлант хугацаанд 398,271.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоны 92 хувь нь барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийн элэгдэл байна. Элэгдлийн зардал нь тайлант хугацааны нийт зардлын 23 хувийг эзэлж байна. Үндсэн хөрөнгийн үр ашигтай ашиглалтын түвшин муу дараах хөрөнгө байгааг онцолж байна. Үүнд дансны үнэ 0 бүхий КАТ трактор, дансны үнэ 53,625.0 мянган төгрөг бүхий 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдөр худалдан авсан Хово машин зэрэг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 904,089.8 мянган төгрөг болж 178,134.7 мянган төгрөг буюу 16 хувиар буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн хувьд татварын өрийг 16,541.6 мянган төгрөг болгон 58,672.5 мянган төгрөг буюу 78 хувиар бууруулсан байна. Нийт өр төлбөрийн 94 хувийг дотоод эх үүсвэрээс авсан урт хугацаат зээл эзэлж байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 8,219,291.8 мянган төгрөг болж 44,297.2 мянган төгрөг буюу 0.5 хувиар өссөн байна. Энд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 379,857.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсанаар өссөн, тайлант хугацааны 335,560.2 мянган төгрөгийн алдагдлын дүнгээр буурсан явдал нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтад заасны дагуу Увс аймгийн Чандмань-Увс ХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралтаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 1,358,554.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,563,469.8 мянган төгрөгөөр буюу 204,915.5 мянган төгрөгийн алдагдалтай баталсныг ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нийт зардлын дүнг 1,576,507.0 мянган төгрөг буюу 13,037.2 мянган төгрөгөөр өсгөж шинэчлэн тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 1,419,169.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,754,729.0 мянган төгрөгийн зардал гарган, 335,560.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,419,169.6 мянган төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 60,615.3 мянган төгрөг буюу 4.5 хувиар илүү байгаа нь орон сууцны айл өрхийн цэвэр бохир усны тариф болон шинээр орон сууц нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,754,729.0 мянган төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 178,222.0 мянган төгрөг буюу 11.3 хувиар хэтэрсэн байна. Энэ нь ажил үйлчилгээний үнийн өсөлт мөн 126,843.1 мянган төгрөгийн маргаантай холбоотой зардал төлөвлөгөөгүй хэмжээгээр гарсан зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 335,560.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 117,607.5 мянган төгрөгөөр илүү байгаа нь гүйцэтгэх захирлын тушаалаар ДЦС-2-д айл өрхөд халуун усаар хангах болсонд төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтийг 2022 оны 6 дугаар сараас 2022 оны 9 дүгээр сар хүртэл үзүүлсэн байдал, цалин хөлс, материалын үнийн өсөлт, төлөвлөгдөөгүй 126,843.1 мянган төгрөгийн зардал гарсан зэрэг нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн “Чандмань-Увс” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудитын дүнг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд “Ариун төгс оршихуй аудит” ХХК-ийн аудитор С.Эрдэнэчимэг, В.Сэлэнгэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь, аудитын менежер М.Бат-Амгалан нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн “Чандмань-Увс” ХХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа “Ариунтөгс Оршихуй аудит” ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,685,579.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 16,855.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан учир гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин шинэчлэн тогтоосон болно. Материаллаг байдлын түвшинг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,754,729.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 17,547.3 мянган төгрөгөөс 80 хувиар 14,037.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцорсон 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

“Чандмань-Увс” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогыг нарийвчлан тусгаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа ялгаатай байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгуулах 17,908.0 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Цалин ба түүнтэй адилтгах зардал, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын өрийн тооцоолол болон үлдэгдлийн баталгаажуулалтад анхаарах.
- Байцаагч тус бүрээр бүртгэсэн үйлчилгээний төлбөр барагдуулалтад анхаарах.
- Төлбөрийн И-баримтаар баталгаажсан худалдан авалт хийгдэж буйг анхаарах.

- Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хэвийн бус хөрөнгө байгаа эсэхэд анхаарах.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардал үүссэн бол СТ-30 тайланд байнгын зөрүү үүсгэсэн эсэхийг нягтлах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 493,543.1 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илэрснээс аудитын явцад 452,142.2 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчил арилгуулах 41,400.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд нэмэгдсэн хөрөнгийг 452,142.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг аудитын явцад залруулга хийллээ.

5.1 Албан шаардлага

Нийтийн аж хуйн үйлчилгээний “Чандмань-Увс” ХХК-ийн 2022 онд 41,400.9 мянган төгрөгийн шатах тослох материал зарцуулахдаа замын хуудас хөтлөхгүй, хяналтгүйгээр зарцуулсан байсанд албан шаардлага өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Байгууллагын дотоод журамтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Увс аймгийн “Чандмань-Увс” ХХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 6.2, 6.10, 6.18 дахь заалтууд нь хууль, тогтоомжид нийцээгүй байх тул шинэчлэх шаардлагатай гэж үзлээ.

Өгсөн зөвлөмж:

Шагнал урамшуулал, буцалтгүй тусламж, тэтгэлэг, бусад мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын заалтуудыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр бусад хууль тогтоомжуудтай нийцүүлэн өөрчлөх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхигдуулсан, андуурсан НББ-ийн алдаа	1	452,142.2			1	452,142.2	1	452,142.2				
Дүн	1	452,142.2			1	452,142.2	1	452,142.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтаар баталгаажуулах зардал гаргасан	2	41,400.9			1	41,400.9	1	0.0				
Дүн	2	41,400.9			1	41,400.9	1	0.0				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЬ/
 АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
 ХХК-ийн АУДИТОР  /В.СЭЛЭНГЭ/

2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 01/22/А2050403
УВА-2023/071НА-СТА-01НА

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК-ийн 2022 онд зарцуулсан 41,400.9 мянган төгрөгийн 9.8 тн шатах тослох материал зарцуулахдаа замын хуудас хөтлөхгүй, хяналтгүйгээр зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 зүйлийн 20.1.4 заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар "Маягт, заавар батлах тухай" тушаалыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шатах тослох материалыг батлагдсан маягтын дагуу жолоочийн замын хуудас хөтөлж зарцуулж байх, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх.

²Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

9200400070


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийтийн аж ахуйн үйлчилгээний "Чандмань Увс" ХХК -ийн захирал Б.Цэцээ, нягтлан бодогч Б.Эрдэнэбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ийн АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.БАЯЛАГ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ